



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: goviusumber@audit.gov.mn

СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛ АРДЫН НАМД

2025.04.22 № 162
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Говьсүмбэр аймгийн Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Говьсүмбэр аймгийн Монгол ардын намын сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг,

42250225

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн

5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Говьсүмбэр аймгийн Монгол ардын намын мөрийн хөтөлбөр (..... хуудас)-г хавсаргав.

Хувийг: Аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт ...6... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН
АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

1. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Орлоготой иргэн

- Аймгийн иргэдийн орлогын түвшинг тогтоон, орлогогүй өрхийн 1 иргэнийг ажлын байраар хангах бодлого баримтлана
- Гэр хорооллын хөгжлийг дэмжин, өрхийн үйлдвэрлэл эрхлэх, хашаандаа хүлэмжийн аж ахуй, хүнсний тариалан эрхлэх боломжийг бүрдүүлнэ.
- Орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажилд орон нутгийн иргэдийг ажиллуулах бодлого баримтлана
- Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлж, ажилгүй иргэдийг сурган, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үр өгөөжийг сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

1.2. Чанартай боловсрол, шинжлэх ухаан, инновацийн хөтөлбөр

- Боловсролыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж, ЕБС, СЭБ-ын багш, ажилчдыг гадаад, дотоодын сургалтанд хамруулж чадавхижуулна.
- Шивээговь суманд ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийг, ашиглалтанд оруулна.
- Сүмбэр сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилгыг ашиглалтанд оруулна.
- Сүмбэр сумын ЕБ-ын 5 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгыг ашиглалтанд оруулна.
- Сүмбэр сумын 6-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг ашиглалтанд оруулна.
- Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллежийг түшиглэн Бүсчилсэн хөгжилтэй холбоотой судалгаа, шинжилгээний ажил хийх, инновацийг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн чиглэлээр сургалтын орчин бий болгох боломжийг бүрдүүлнэ.
- Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулна.

1.3. Тогтвортой-амар амгалан гэр бүл

- Гэр бүлийн хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Орон сууцны газруудыг тусгаж хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэн, 600 айлын орон сууцыг шинээр барьж ашиглалтанд оруулна.
- Түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Сүмбэр суманд дахин төлөвлөлт хэрэгжүүлж иргэдийг орон сууцжуулна. / 6 байшин, Багш нарын байр г.м/

- Сүмбэр суманд "Жишиг гудамж" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэвэр усны төвлөрсөн шугаманд гэр хорооллын айл өрхүүдийг үе шаттай холбоно.
- Гэрлэх ёслолын ордон байгуулна.
- Жендерийн тэгш байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэн, нийгэм дэх эмэгтэйчүүдийн хөгжил, оролцоог дэмжинэ.
- Хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих боломжийг бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.4. Ахмадуудад үзүүлэх үйлчилгээ

- "Ахмадын өргөө"-ний барилгыг ашиглалтад оруулж, ахмад насны хөгжлийн төвийг байгуулна.
- Ахмадуудын хөдөлгөөн эрүүл мэндэд чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллана.

1.5. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийг дэмжих

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- Зорилтот бүлэгт чиглэсэн арна хэмжээг хэрэгжүүлэн, тусгай хэрэгцээт иргэдийн хөгжлийг хангана.
- Тусгай хэрэгцээт иргэдийн дэд бүтцийг сайжруулж, шинээр баригдаж байгаа зам, талбай, барилга байгууламжид тусгай хэрэгцээт иргэд саадгүй зорчих нөхцлийг бүрдүүлнэ.

1.6. Хүүхэд хамгаалал, хөгжил


- Хүүхэд хамгааллын төвийн үйл ажиллагааг дэмжин, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэргийг бууруулна.
- Аймгийн Хүүхдийн ордныг байгуулна, хүүхдийн хөгжлийг дэмжинэ.
- Хүүхдийн хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд СҮҮ хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.7. Үндэсний бахархал, өв, соёл

- Боржигин өв соёлыг түгээн дэлгэрүүлж, залуу үед өвлүүлэх, сурталчлан таниулах эвент арга хэмжээг зохион байгуулна.
- Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын байгууллагуудыг олон улсын болон улсын чанартай үзэсгэлэнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.
- Соёл, урлагийн байгууллагуудыг дэмжин, үйл ажиллагааг өргөжүүлж, хөдөөгийн багийн иргэдэд явуулын үйлчилгээ үзүүлнэ.

1.8. Оюутан, залуучуудаа дэмжинэ

- Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж буй болон төгсөөд орон нутагтаа ажиллах оюутнуудад сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.



Handwritten signature

000000002

- Ерөнхий боловсролын сургуулийн бүх сурагчийн үдийн хоолны хөтөлбөрт хамруулж, сургууль бүрийг стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцөөр хангана.
- Орон нутагт ажиллахаар ирж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдыг орон байраар хангах бодлогыг хэрэгжүүлнэ.
- Залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн, залуучуудын хөгжил, оролцоог нэмэгдүүлнэ.
- Сүмбэр суманд хүүхэд, залуучуудын ордон барина.
- Баянтал суманд спорт заалыг ашиглалтанд оруулна.
- Шивээговь, Баянтал суманд 200 хүний суудалтай соёлын ордон шинээр барьж ашиглалтанд оруулна.
- Баянтал суманд стандартын шаардлага хангасан хөлбөмбөгийн талбай шинээр барьж ашиглалтанд оруулна.

1.9. Эрүүл иргэн

- Эрүүл мэндийн салбарыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн, эмч, ажилтнуудыг гадаад, дотоодын сургалтанд хамруулж, чадавхижуулна.
- Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдийг орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангаж, технологийг нутагшуулж эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Нийтийн биеийн тамир, спортыг дэмжин, иргэдийн нийтийн биеийн тамираар хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлнэ.
- Усан бассейн бүхий спорт цогцолбор ашиглалтанд оруулна.
- Бүжгийн клубын үйл ажиллагааг дэмжин ажиллана.

2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Уул уурхай, хүнд аж үйлдвэр

- Шивээ-Овоогийн уурхайг түшиглэн 30мвт-н хүчин чадалтай цахилгаан станц байгуулна.
- Сүмбэр сумын 1 дүгээр багт дахин төлөвлөлт хийж, төмөр замыг түшиглэн уул уурхай, аж үйлдвэрийн бүс байгуулан хөгжүүлнэ.
- Сүмбэр сумын 1,3 багийн дулаан, цэвэр усны инженерийн шугамын өргөтгөл шинэчлэлийн ажлыг хийнэ.

2.2. Эдийн засгийн салбарын өсөлт, төрөлжилт

- Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн, дэд бүтцийг бий болгон, Боржигин өв соёлд тулгуурлан, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- Цэргийн алдрын хөшөөний бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлж, аялал жуулчлал, спортын цогцолборыг байгуулна.
- Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд хөнгөн болон хүнсний үйлдвэрийн салбарыг дэмжин, сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс шир боловсруулах, мал нядалгаа, мах боловсруулах үйлдвэрүүдийг байгуулна.
- Түүхий эдийн бүтээгдэхүүн борлуулах сүлжээг бий болгон, зоорь, агуулахын тоог нэмэгдүүлнэ.

- Газар тариалангийн хөгжлийг эрчимжүүлж, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэн, өвлийн хүлэмжийн тариалалтыг бий болгоно.
- Баянтал суманд эрчимжсэн мал аж ахуйн эко парк байгуулах ажлыг бодлогоор дэмжиж, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.
- Бэлчээрийн доройтлыг бууруулах зорилгоор тэжээлийн ургамал тариалалт, усжуулалтыг нэмэгдүүлнэ.

2.3. Бизнес, худалдаа, үйлчилгээ

- Орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжиж, тендер, худалдан авах ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлнэ.
- Тусгай зөвшөөрлийг хүнд суртал чирэгдэлгүй, хурдан шуурхай олгох нөхцлийг бүрдүүлж, цахим системийг нэвтрүүлнэ.
- Олон улсын чанартай зам дагуу худалдаа, үйлчилгээний төв байгуулна.
- Шивээговь, Баянтал суманд ахуйн үйлчилгээний төв байгуулна.

2.4. Дэд бүтэц, хөрөнгө оруулалт

- Аймгийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, дахин төлөвлөлтийг хийн, нийтийн эзэмшлийн орон сууцны тоог нэмэгдүүлнэ.
- Баянтал сумын төвийг босоо тэнхлэгийн авто замд холбох ажлыг үргэлжүүлэн ашиглалтанд оруулна.
- Шинээр олгосон өмчлөлийн газруудыг цахилгаан дамжуулах шугаманд холбож, гэр хорооллын цахилгаан хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- Говьсүмбэр-Хэнтий аймгийн хооронд байрлах Хүмэлтэйн 220м гүүрний зураг төсвийг хийж шинэчилж барина.
- Олон улсын төмөр зам, авто зам, Баянтал сумын аэродромыг түшиглэн тээвэр, ложистикийн төв байгуулна.
- Аймгийн төвд дулааны станц, цэвэрлэх байгууламжийг ашиглалтанд оруулна.
- Нийтийн эзэмшлийн гудамж, сангийн тохижилтыг сайжруулж, аймаг, сумдын төвийн авто болон дугуй, явган хүний замыг үргэлжлүүлнэ.
- Аймаг, сумдын шилэн кабель, цахилгаан холбооны сүлжээг өргөтгөж, хөдөөгийн багийн иргэдийг интернет сүлжээнд холбон, үүрэн телефоны хэрэглээг нэмэгдүүлнэ.
- Сүмбэр сумын 1 дүгээр багийн бохирыг аймгийн төв цэвэрлэх байгууламжид холбох ажлыг дуусган, Найрамдал хотхонд ус зайлуулах шугамыг байгуулна.
- Говьсүмбэр-Мандалговь чиглэлийн авто зам ашиглалтанд оруулна.
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд авто үйлчилгээний төв байгуулна.
- Шивээговь сум доторх 2,5 км засмал зам тавих

3. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

3.1. Шударга ёсны засаглал, цахим Монгол, Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба

- Төрийн байгууллагуудын үйлчилгээг цахимжуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, төрийн үйлчилгээний төв байгуулан, иргэдэд цахимаар болон нэг цэгээс хурдан шуурхай, чирэгдэлгүй төрийн үйлчилгээг хүргэнэ.
- Иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай, чирэгдэлгүй, чанартай хүргэх зорилгоор төрийн байгууллагуудын барилгыг шинээр барих, засварлах, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээг шат дараатайгаар авч хэрэгжүүлнэ.

- Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэн, тушаал, шийдвэр, үүргийн биелэлтийг цахимаар хянадаг болно.
- Төрийн албан хаагчдыг гадаад, дотоод сургалтанд хамруулан чадавхижуулж, ёс зүй, хандлагыг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлнэ.
- Сум, багийн түвшинд төрийн үйлчилгээ үзүүлж байгаа ажилтан, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлж, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулна.
- Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг ханган, хөнгөлөлттэй нөхцлөөр орон сууцаар хангана.

3.2. Ардчилсан, хүний эрхийг дээдэлсэн, амар тайван, аюулгүй нийгэм

- Нийтийн эзэмшлийн гудамж, талбай дахь камер болон гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлнэ.
- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв, түр хамгаалах байрны орчин нөхцлийг сайжруулна.
- Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог сайжруулж, оюутан цэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтыг сайжруулна.
- Орон нутгийн аюулгүй байдлыг хангах үүднээс бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хярогчид бүхий махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий хүнсний агуулах барихыг дэмжинэ.

4. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4217144454
УСА0055 9019049

4.1. Баталгаатай ундны ус, хариуцаатай уул уурхай

- Ундны усны эх үүсвэрийг хамгаалж, зөөлрүүлэх болон цэвэршүүлэх төхөөрөмжийг суурилуулна.
- Аймгийн төвийн усан хангамжийн найдвартай байдлыг бүрдүүлэн, цэвэр усны нөөц шугамыг шинээр татна.
- Булаг, шандны эхийг хамгаалах ажлыг үргэлжлүүлнэ.
- Хөдөөгийн багт хүн амын усан хангамжийг сайжруулан, худгийн тоог нэмэгдүүлнэ.
- Уул уурхайн хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Шивээговь сумын усан хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтыг сайжруулж, цэвэрлэх байгууламж ашиглалтанд оруулна.
- Аймаг, сумдын төвийн хог хаягдлын менежментийг сайжруулж, туурь хог хаягдал бүхий талбайг үе шаттайгаар бууруулж, аймгийн төвд ландфилл технологийг сайжруулна.

4.2. Ногоон хөгжил, сэргээгдэх эрчим хүч, амьдралын таатай орчин бүхий ногоон хот

- Иргэдийн оролцоог дэмжин, мод тарьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулна.

000000035

- Төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, сум бүрд бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулна..
 - Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.
- 4.3. Хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлт
- Агаарын бохирдлыг хянах хяналтын цэгийн тоог нэмэгдүүлж, гэр хорооллын иргэдийн сайжруулсан түлшээр хангана.
 - Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын өрхийг био жорлонгоор хангаж, нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлын цэг, ариун цэврийн байгууламжуудыг сайжруулан, хөрсийг тогтмол ариутгана.
 - Туурь балгас, хур хог хаягдлыг бууруулж, газрыг нөхөн сэргээнэ.
 - Ойн зурвас байгуулах ажлыг үргэлжлүүлж, Сум дундын ойн ангийн үйл ажиллагааг дэмжиж, чадавхижуулна.
 - Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэн, Чойрын богд уулын Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөж, биологийн төрөл зүйл, аргаль хонийг хамгаалан, ховор болон ховордсон амьтдыг сэргээн нутагшуулна.
 - Цаг уур, орчны шинжилгээний байгууллагыг чадавхижуулж, цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
 - Иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, байгаль хамгаалах нөхөрлөл, идэвхтэн байгаль хамгаалагчдыг дэмжин, урамшуулна. УСА0055 9019049
 - Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд худаг гаргаж, усалгааны систем байгуулна.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

000900006